



2024

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

01



БИДНИЙ ТУХАЙ

- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Голлох үзүүлэлтүүд
- Тогтвортой хөгжлийн бодлого ба менежмент

02



НОГООН ДЭЛХИЙ

- Сав баглаа боодлын менежмент
- Эрчим хүч, усны хэрэглээ
- Хог хаягдлын менежмент
- Ногоон байгууламж

03



САЙН САЙХАН ОРШИХУЙ

- Эрүүл, инновацлаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Олон улсын стандартуудыг дагаж мөрдөх
- Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих
- Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ

04



МФС АЖИЛТНУУД

МФС Хүний нөөц

МФС Хөдөлмөрийн
аюулгүй байдал, эрүүл
ахуй

МФС Соёл

05



ИЛ ТОД БАЙДАЛ

Засаглал

Хяналт,
тайлагнал

1

БИДНИЙ ТУХАЙ



МОНОС ХҮНС ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Монос Хүнс ХК-ийн Гүйцэтгэх захирал
А.ОТГОНДАРЬ

Эрхэм хувьцаа эзэмшигчид, хэрэглэгчид, түншүүд, оролцогч талууд Та бүхэнд,

Монгол Улсын ууган компаниудын нэг Монос группийн 35 жилийн туршлагад суурилан Монос Хүнс ХК нь эрүүл мэндийг дэмжих хүнсний бүтээгдэхүүнээ 13 дахь жилдээ үйлдвэрлэн хүргэж байгаа билээ.

Бид 2019 онд олон нийтэд нээлттэй хувьцаат компани болж, ил тод, нээлттэй, хариуцлагатай засаглалын зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тогтвортой хөгжлийн бодлогыг стратегийн тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, хүн, байгаль, нийгэм, эдийн засаг, технологийн хариуцлагатай тэнцвэрийг хадгалахыг зорьж байгаа юм.

2024 онд тогтвортой хөгжлийн бодлогынхоо хүрээнд засаглал, ажилтнуудын хөгжлийн орчин, боломжийг дэмжих, ХАБЭА, байгаль орчин, усны нөөцийн ухаалаг ашиглалтууд, хаягдалгүй үйлдвэрлэл, нийгмийн сайн сайханд чиглэсэн хөрөнгө оруулалт зэрэг олон чиглэлд гаргасан үр дүнгээ танилцуулж байна.

Тайланд дурдагдсан ажлуудаас “MFC Төгөл” буюу гурван жилийн хугацаанд 1000 мод тарих төслийг онцолж байна. Ирээдүй үеэ устай үлдээхийн тулд усны хэмнэлттэй, зохистой хэрэглээнд өөрсдийн хувь нэмрээ оруулж, саарал усны хэрэглээг 20% -иар нэмэгдүүллээ. Мөн сэргээгдэх эрчим хүчийг гадна орчны гэрэлтүүлэгт ашиглаж байна.

Монос Хүнс ХК нь эрүүл мэндийн хуурай болон шингэн хүнсний үйлдвэрлэлийг нэгтгэсэн MFC 2.0 төслийн хүрээнд хуванцар сав, уутны хэрэглээ, цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулсан дэвшилтэт технологи ашиглан бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байна. Түүнчлэн бид саарал усаа нөөцлөн дахин ашиглах, хог хаягдлаа дахин боловсруулалтад хүргэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллөө тогтмол бүртгэж хянадаг тогтолцоотой.


Тогтвортой хөгжлийн бодлого бол зүгээр нэг цаасан дээр бичсэн зүйл төдий биш, хэмжигдэхүйц үр дүн, бодит ахиц дэвшлийг бий болгох ёстой. “Хэмжиж чадахгүй бол хэмнэж ч, удирдаж ч чадахгүй” гэдэг зарчмын дагуу хэрэглээ бүрээ нарийн хэмжиж, бүртгэж, хянаж, үнэлж, сайжруулах нь тогтвортой хөгжлийн үндэс тул үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

2025 онд бид ус дахин ашиглалтын хэмжээг 33%-д хүргэх, хуванцрын хэмжээг 52 тонноор бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлд анхаарч байна. Мөн үйлдвэрлэлийн осолгүй ажиллах, үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн тооцооллыг хийлгэхээр зорьж буй юм.

Бид энэхүү тайлангаараа дамжуулан Монос Хүнс ХК-ийн нийгмийн хариуцлага, байгальд ээлтэй үйл ажиллагаа, хамтын үнэ цэний төлөөх бодлого, хүчин чармайлтаа хуваалцаж байгаадаа баяртай байна. Итгэл, дэмжлэгээрээ үргэлж бидэнтэй хамт байдаг та бүхэндээ дахин талархал илэрхийлье. Цаашид ч бид тогтвортой хөгжлийг түүчээлэгч үндэсний үйлдвэрлэгч байхын төлөө тууштай ажиллах болно.

2024 ОНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БАЙГАЛЬ ОРЧИН:




НИЙГЭМ:



ЭДИЙН ЗАСАГ:



ЗАСАГЛАЛ:



БОНЗ-ын МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Компанийн үйл ажиллагаа ба оролцогч талуудын анхаарал нэн тэргүүнд хандуулах чухал асуудлуудыг эрсдэл, үр дагавар, нөлөөллөөр харьцуулан тодорхойлсон.



- БАЙГАЛЬ ОРЧИН
- НИЙГЭМ
- ЗАСАГЛАЛ

БОНЗ АМЛАЛТ

Байгаль орчин:

Бид байгалийн нөөцийг зөв зохистой ашиглан үйлдвэрлэл эрхлэхдээ хаягдалгүй үйлдвэрлэлийг бий болгохыг зорьж байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгаж экологийн тэнцвэрт байдлыг хангаж ажиллана.

Нийгэм:

Бид БОНЗ-ын үлгэр жишээ соёлыг хэвшүүлэхэд ажилтан бүрийн оролцоог ханган, зохистой хөдөлмөрийн харилцааг эрхэмлэн, эрүүл аюулгүй, хүнд ээлтэй ажлын байрыг бий болгоход эрмэлзэнэ.
Бид зохистой худалдан авалтыг дэмжиж, тогтвортой ханган нийлүүлэлтийг дэмжин ажиллана.

Засаглал:

Монос Хүнс компани нь хариуцлагатай БОНЗ-н тогтолцоог бүрдүүлж, шударга ёс зүйтэй байхыг сурталчлан таниулна.

2025 ОНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗОРИЛТ

6 БАТААГААТ ЭХЭМЖИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААГ БЭРХЭМЛЭН 	Ус дахин ашиглалтын хэмжээг 33% -д хүргэх
13 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРХЛЭХДЭЭ ХАЯГДАЛ БЭРХЭМЛЭН 	52 тонн хуванцар хаягдал байгальд үүсэхээс сэргийлэх
13 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРХЛЭХДЭЭ ХАЯГДАЛ БЭРХЭМЛЭН 	Компанийн үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хий 600.1 CO2 тонн ба дахин тооцоолол хийлгэх
3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ 	0 - Үйлдвэрлэлийн осолгүй ажиллах

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД НИЙЦСЭН БАЙДАЛ

Монос Хүнс компани нь НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилтоос 14 зорилтод хамаарах ажлуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хувь нэмэр оруулан ажиллаж байна.

3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ 	3.8 Эрүүл мэндийн үйлчилгээ 3.9 аюултай химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол 3.d Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрсдэлийг бууруулах Ажилчдыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахын зэрэгцээ хүнсний үйлдвэрийн ажилчдын хувьд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг жилд хоёр удаа хийлгэж, эмчийн зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэдэг.
6 БАТАЛГААТ ТӨРНИЙ УС ХӨРӨНГӨМЖИЙГ БАЙГУУЛАХ 	6.1.Баталгаат ундны ус 6.2 Тэгш хүртээмжтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж 6.3 Усны чанар 6.4 Хэмнэлттэй усны хэрэглээ Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа усны хэмнэлттэй технологийг нэвтрүүлж, ариун цэврийн стандартыг чандлан сахиж, ажиллагсдыг эрүүл, аюулгүй ажлын орчноор хангахад анхаарч ажилладаг.
4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ 	4.3 Чанартай техникийн, мэргэжлийн болон дээд боловсрол 4.7 Тогтвортой хөгжлийн мэдлэг, боловсрол 260 гаруй ажиллагсдын сурч боловсрох нөхцөлөөр ханган, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр ур чадварын матрицаар үнэлгээ хийж, сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг.
7 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ 	7.2 Сэргээгдэх эрчим хүч 7.3 Эрчим хүчний үр ашиг, хэмнэлт Үйлдвэрийн байгууламжийн гадна талбайн гэрэлтүүлгийг нарны эрчим хүчээр шийдвэрлэсэн ба илүүдэл эрчим хүчийг оффисын хэрэглээнд ашиглаж байна.
8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ӨЗДЭГ ЗАСГИЙН БЭЛТЭЙГ ДЭМЖИХ 	8.3 Бичиг, жижиг, дунд бизнесийг дэмжих, зохистой ажлын байр 8.5 Бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлэлт 8.8 Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, аюулгүй ажиллах орчин 260 гаруй ажилтныг тогтвортой ажлын байраар хангаж, ажиллах таатай орчин нөхцөлөөр бүрдүүлэн ажиллаж байна.
5 ХӨНДӨРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ 	5.1 Бүх эмэгтэйчүүд, охидын ялгаварлан гадуурхалт 5.5 Эмэгтэйчүүдийн манлайлал 5.a Эмэгтэйчүүдийн эдийн засгийн тэгш эрх Компанийн нийт ажилчдын 46 хувийг эмэгтэй, 54 хувийг эрэгтэй ажилтнууд эзэлж байна. Гүйцэтгэх удирдлагын түвшинд эмэгтэйчүүд 59 хувийг, эрэгтэйчүүд 41 хувийг бүрдүүлж байгаа бол удирдах зөвлөлийн гишүүдийн 55 хувь нь эмэгтэй, 45 хувь нь эрэгтэй байна.
9 ИННОВАЦИ БОЛОН ӨЗД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 	9.4 Дэд бүтцийг хөгжүүлж, аж үйлдвэрийн боловсронгуй болгох Байгальд ээлтэй технологийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ, инновацыг дэмжих чиглэлээр ажилладаг.

ТХЗ-д УЯЛДАЖ БУЙ БАЙДАЛ

ТХЗ-д ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

10 ТЭГШ БҮС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ	10.2 Эрх тэгш оролцох боломж (нийгэм, эдийн засаг, улс төр) 10.3 Ялгаварлан гадуурхлыг халах 10.4 Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх 10.6 Үр дүнтэй, хариуцлагатай засаглал Бодлогын хүрээнд бид оролцогч талуудтай харилцах бүхий л үйл ажиллагаандаа хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хүндэтгэн ажиллахыг зорьдог.	15 ХУУРАЙ ГАЗРЫН ЭКО СИСТЕМИЙГ ХАМГААЛАХ	15.2 Ойн тогтвортой менежмент 15.6 Генетикийн нөөц баялгийн ашиглалт 15.7 Ургамлын болон амьтны хулгайн ан Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд бий болсон саарал усыг дахин ашиглаж, дотоодын хэрэгцээнд болон зам талбайн усалгаанд 20%-ийг ашигласан.
11 ЗЭЛТЭЙ ХОГ ХАЯГДЛЫН ОРЛОЦООГ ДЭМЖИХ	11.4 Соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах 11.6 Агаарын чанар, хог хаягдлын менежмент 11.7 Ногоон болон нийтийн эзэмшлийн талбай Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлын 10%-ийг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн.	16 ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ	16.3 Хүн бүрийг хуулиар хамгаалуулах тэгш боломж 16.5 Авилгал, хээл хахууль 16.7 Бүх талын оролцоотой, төлөөллийн шийдвэр 16.8 Засаглалын үйл ажиллагаа 16.b Тогтвортой хөгжлийн буюу үл ялгаварласан бодлого Бодлогын хүрээнд мэдээллийн ил тод байдал, хуулийн нийцлийг чандлан хангаж, хээл хахууль, авлига болон хувийн ашиг сонирхлоос ангид шударгаар ажиллахыг эрхэмлэдэг бөгөөд шүгэл үлээх журмыг хэрэгжүүлэн, засаглалын кодексийн үнэлгээг жил бүр тогтмол хийдэг.
12 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ	12.2 Байгалийн баялагын үр ашигтай хэрэглээ 12.4 Химийн бодис, бүх төрлийн аюултай хог хаягдлын менежмент 12.5 Хог хаягдлын хэмжээг бууруулах 12.6 Компани, аж ахуйн нэгжийн тогтвортой байдал 12.8 Тогтвортой хөгжил, байгальд дэлхийтэйгээ зохицон амьдрах амьдралын хэв маягийн талаарх мэдлэг мэдээлэл Экос усны хуванцарын хэрэглээг 30%-иар бууруулсанаар 2024 оны 4-р улиралд 43 тонн хуванцар, 92 тонн хүлэмжийн хийг бууруулсан бол 2025 онд үйлдвэрлэлийн тооцооллоор 152 тонн хуванцарын хаягдал, 365 тонн хүлэмжийн хий агаар мандалд бий болохоос сэргийлж байгаль орчиндоо бодит хувь нэмэр оруулж байна.	17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТНЦШЛЭЛИЙГ БЭЛЭТЛЭХ	17.4 Өрийн дарамтыг бууруулах 17.11 Хөгжиж буй орнуудын экспорт 17.16 ТХЗ-д хүрэх хамтын ажиллагаа 17.17 Төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн үр дүнтэй түншлэл Монос Хүнс ХК нь олон улсын болон үндэсний байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, тогтвортой хөгжлийг дэмжих олон талт түншлэлийг бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулсаар байна. Жил бүр дотоодын эмнэлгүүдэд хүүхдийн өрөө тохижуулах санаачилгыг хэрэгжүүлэн, нийгмийн хариуцлагын хүрээнд бодитой ажлуудыг тасралтгүй зохион байгуулж байна. Мөн Монос Хүнс ХК нь Бүгд Найрамдах Киргиз Улсын эм ханган нийлүүлэлтийн "Лекарь" ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээ тус улсад албан ёсоор экспортлон борлуулж эхэлсэн.
13 ҮҮР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨЛГ БАГАСТЛАХ	13.2 Цаг уурын өөрчлөлтийн бодлого 13.3 Цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахыг зорин ажилладаг ба MFC төгөл байгуулах хөтөлбөрийн эхлэлийг тавин ажиллав.		ТХЗ-Д УЯЛДАЖ БҮЙ БАЙДАЛ ТХЗ-Д ОРУУЛЖ БҮЙ ХУВЬ НЭМЭР

2

НОГООН ДЭЛХИЙ



САВ БАГЛАА БООДЛЫН МЕНЕЖМЕНТ

MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төслийг амжилттай хэрэгжүүлснээр “Экос” усны хуванцрын хэрэглээг **30%-иар бууруулж, 43 тонн хуванцар хаягдлаас сэргийлээд байна.** Мөн “Энхжин” цайны савлагааг шинэчилж, хуванцрын хэрэглээг **90%, цаасны хэрэглээг 30%-иар бууруулснаар 24 тонн хог хаягдлаас сэргийллээ.**

Байгаль орчинд ээлтэй “нимгэн савлагаатай” бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нөөцийн зохистой хэрэглээг дэмжин цаашид жилд **152 тонн хуванцар хаягдал ≈365 тонн нүүрсхүчлийн хий** байгальд хаягдахаас урьдчилан сэргийлэхийг зорьж байна.



ЭРЧИМ ХҮЧ, УСНЫ ХЭРЭГЛЭЭ



Нарны эрчим хүчний хэрэглээг нэвтрүүлэх зорилгоор гадна орчны **1300м2 талбайн гэрэлтүүлгийг нарын эрчим хүчээр ханган**, илүүдэл эрчим хүчийг **оффисын хэрэглээнд** ашиглаж байна.

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд **46%-ийн цахилгааны хэрэглээг** бууруулсан.



Усны зохистой хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор нийт усны хэрэглээний **20%-ийг дахин ашигласан** ба ариутгал цэвэрлэгээ, ахуйн хэрэглээнд болон гаднах байгууламжийн зам талбайн усалгаанд дахин ашигласан байна.




Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд **13,8% -иар усны ашиглалтыг** бууруулсан.



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ


Үйл ажиллагаанаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлс, хүлэмжийн хийн ялгарал болон агаар, ус, хөрсний бохирдлыг боломжит хамгийн бага байхад тэмүүлэх бодлогын хүрээнд байгаль орчны менежментийн тогтолцоог цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлдэг.

Эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх тогтолцоог хэрэгжүүлэн дотооддоо хэвшүүлэх ажлуудыг тогтмол зохион байгуулдаг.



ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

Ахуйн хаягдал	Аюултай хаягдал	Хуванцар хаягдал	Хатуу карто	Гялгар уут
194,9тн	0,9тн	12,4тн	4,9тн	1,2тн



Нийт хог хаягдлын 10%-ийг дахин боловсруулсан байна.

Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгадаг ба **дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэн ажилладаг.**

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ



Компанийн гаднах ногоон байгууламжийн хэмжээ 200м² байна. **Нийт 700ш мод тарьж, арчлан ургуулж байна.**

MFC төгөл буюу Баянгол цэцэрлэгт хүрээлэнд 3 жилийн хугацаанд 1000 мод тарихаар төлөвлөсөн ба **2024 онд эхлүүлэв.**



3

САЙН САЙХАН
ОРШИХУЙ

3

ЭРҮҮЛ МЭНДИЙГ
ДЭМЖИХ



9

ИННОВАЦИ БОЛОН
ДЭД БҮТЦИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ



10

ТЭГШ БҮС
БАЙДЛЫГ
БУУРУУЛАХ



12

ХАРИУЦЛАГАТАЙ
ХЭРЭГЛЭЭГ
ДЭМЖИХ



17

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ТҮНШЛЭЛИЙГ
БЭЭЖҮҮЛЭХ



ЭРҮҮЛ, ИННОВАЦЛАГ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

Эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй хуурай болон шингэн хүнсний 12 брэндийн 72 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Монос Хүнс ХК-ийн бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд Эм Судлалын Хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын хөдөлмөр, олон улсын судалгаа шинжилгээ, уламжлалт анагаах ухаан, ардын анагаах ухааны үе дамжуулан хадгалсан мэдлэг туршлага, эх орны эрүүл хөрсөн дэх шимт нэгдэл, орчин үеийн шинжлэх ухааны шилдэг инновац зэрэг олон хүчин зүйлсийг шингээн дунджаар 1-5 жилийн хугацааг зарцуулж хэрэглэгчдийн гарт хүргэж байна.



БАРАГШУН
өтлөрүүцсэн

ДАРХЛАА
САЙЖРУУЛАХ

ХОДООДНЫ
УЛАЙЛТ, ШАРХЛАА

ЯСНЫ
ХУГАРАЛТ

ЧИХРИЙН
ШИЖИН

ЗҮРХ
СУДАСНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ

ЭД ЭСИЙН
НӨХӨН
ТӨЛЖИЛТ

ЭЛЭГ, БӨӨР
ЦӨСНИЙ
ҮРЭВСЭЛ

БҮХ ТӨРЛИЙН
ХАРШИЛ

SHOT

MORE HEALTH

VITOS

БАРАГШУН АЛТАНГАЛХУР 20 МЛ

ХАР САРИМС 20 МЛ

БӨӨР ХАНГААЛДЧ 20 МЛ

ЭРҮҮЛ БИЕИЙН ТӨЛӨӨ

ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУДЫГ ДАГАЖ МӨРДӨХ

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор FSSC 22000 (Хүнсний аюулгүй байдал), ISO 14001 (Байгаль орчны удирдлагын тогтолцоо), ISO 9001 (Чанарын удирдлагын тогтолцоо), ISO 17025 (Лабораторийн чадавх) зэрэг олон улсын стандартуудыг амжилттай нэвтрүүлж, **Швейцарын SGS байгууллагаар баталгаажуулж**, гэрчилгээ гардлаа.



Хүнсний аюулгүй
байдлын
тогтолцоо
FSSC 22000



Чанарын
удирдлагын
тогтолцоо
ISO 9001



Байгаль орчны
чанарын удирдлагын
тогтолцоо
ISO 14001



Лабораторийн
итгэмжлэл
ISO 17025



ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ ДЭМЖИХ



Хөвсгөл эрчим баг нь үндэсний дээд лигийн 2024-2025 оны хүрэл медалын эзэд болж, бахдам амжилтыг үзүүлсэн. Монос Хүнс ХК-ийн Vitos Цэнэг брэнд нь уг Хөвсгөл эрчим багтай хоёр дах жилдээ хамтран ажиллаж байгаа юм.



ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ ДЭМЖИХ




Монголын сагсан бөмбөгийн холбооны Үндэсний дээд лигийн **BCN Knights** баг болон Парис-2024 зуны XXXIII олимпын наадамд оролцох **Монголын чөлөөт бөхийн баг** тамирчидтай **Экос** брэнд хамтран ажиллав.



ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ ДЭМЖИХ


Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК-ийн эмч төлөөлөгчид 2024 онд нийт 153 удаагийн **3883 хүнд** эрүүл мэндийн мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа.



Сувилал



Өрхийн эрүүл
мэндийн төв



Харилцагч
байгууллагууд



Шинэ ажилтнуудын
чиглүүлэх сургалт

Эмийн сан
болон
эм ханган
нийлүүлэх
байгууллага



МФС АЖИЛЧДЫН СПОРТ, ЭРҮҮЛ АМЬДРАЛЫГ ДЭМЖИХ НЬ



Монос Хүнс ХК нь ажилтнуудынхаа эрүүл мэнд, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж ажилладаг. Бид компанийн Хангамжийн менежер, хөлбөмбөгийн 1-р зэргийн тамирчин Мөнхзулын Бямбасүрэн-тэй ярилцлаа.

Сайн уу, Та Монос Хүнс ХК-д хэдийнээс эхлэн ажиллаж байна вэ?

Сайн байна уу. Би 2018 онд их сургуулиа бизнесийн эдийн засгийн чиглэлээр төгсөөд, тэр оны 8 сард Монос Хүнс ХК-д няравын албан тушаалаар ажилд орсон. 2019 онд тушаал дэвшин хангамжийн албаны менежерээр ажиллаж эхэлсэн. Ийнхүү нийтдээ 7 дахь жилдээ ажиллаж байна.

Та хөлбөмбөгийн спортоор хэзээнээс хичээллэж эхэлсэн бэ?

Би ерөнхий боловсролын сургуулийн 8-р ангид байхдаа хөлбөмбөгөөр хичээллэж эхэлсэн. Сургуулийнхаа багт тоглон Хан-Уул дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа түрүүлж, “Дуулиан 2020” тэмцээнээс хүрэл медаль хүртсэн. Үүний үр дүнд 1-р зэргийн тамирчны болзол хангасан.

Спортын карьерынхаа хүрээнд ямар амжилт гаргасан бэ?

2018 онд их сургуулиа төгсөх жилдээ Khan-Uul FC багт элсэж, Улсын аваргын

тэмцээнд оролцон хүрэл медаль хүртсэн. Үүний дараа 1-р лигт гурван улирал дараалан тоглосон. Харин 2021 оноос эхлэн Hunters FC багт нэгдэн дараах амжилтуудыг гаргасан:

2022–2023 оны улирал – Үндэсний 2-р лигийн аварга болж, улирлын “Шилдэг довтлогч”-оор шалгарсан

2023–2024 оны улирал – Үндэсний 1-р лигийн аварга болсон

2024–2025 оны улирал – Үндэсний дээд лигт дэвшин тоглож байна.

Монос Хүнс ХК-ийн зүгээс спорт, эрүүл амьдралыг хэрхэн дэмжиж байна вэ?

Компанийн зүгээс миний спортын үйл ажиллагаанд цагийн уян хатан нөхцөлөөр дэмжлэг үзүүлдэг. Жишээлбэл, бэлтгэл болон тэмцээний хуваарьт тохируулан ажилдаа уян хатан цагийн зохицуулалт хийх боломжийг олгодог. Энэ нь спортдоо тууштай, үр дүнтэй хандсаар байх боломжийг бүрдүүлдэг.

Монос Хүнс ХК болон Hunters FC багийн хамтын ажиллагаа хэзээнээс эхэлсэн бэ?


2024 оноос эхлэн Монос Хүнс ХК нь Экос брэндээрээ дамжуулан Hunters FC багийн албан ёсны ивээн тэтгэгч болсон. Энэхүү хамтын ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж, илүү үр өгөөжтэй болж байгаа нь компанийн спортыг дэмжих бодлогын тод жишээ юм.

Танд баярлалаа. Цаашдын тэмцээн уралдаанд нь өндөр амжилт хүсье!

Баярлалаа. Компанийнхаа дэмжлэгийг үргэлж мэдэрч явдгаа энэ дашрамд илэрхийлэн, та бүхэнд ажлын амжилт хүсье.

М. Бямбасүрэн

ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ




Худалдан авалтын үйл ажиллагааны журмын хүрээнд:

- Шууд худалдан авалт
 - Харьцуулсан судалгаагаар худалдан авалт
 - Тендерийн худалдан авалт
 - Онцгой нөхцөлийн худалдан авалт
- зэргээр бэлтгэн нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг.

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Бэлтгэн нийлүүлэгчийг үнэлэх, гүйцэтгэлд хяналт хийх журмын хүрээнд 2024 онд **сав баглаа, түүхий эд материал болон бараа, ажил үйлчилгээний чиглэлийн 29 аж ахуйн нэгжүүдэд** үнэлгээ хийгдсэн ба үйл ажиллагааны чиглэл, хүнсний аюулгүй байдал, байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд зөвлөн, туслах, дэмжлэг үзүүлэх үйл ажиллалааг хэрэгжүүллээ.

Бэлтгэн нийлүүлэгч компани



4

МҮС АЖИЛТНУУД



MFC ХҮНИЙ НӨӨЦ

НИЙТ АЖИЛТАН **268**ЭРЭГТЭЙ
138ЭМЭГТЭЙ
122УДИРДАХ АЖИЛТАН **17**
ҮҮНЭЭС ЭМЭГТЭЙ 10ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
АЖИЛТНЫ ТОО **11**

BABY BOOMERS

2023 2.4%
2024 2.7%

GEN X

2023 13.2%
2024 17.6%

MILLENNIAL

2023 63.8%
2024 60.7%

GEN Z

2023 20.6%
2024 28.2%АЖИЛТНЫ
ЭНГЭЙЖМЕНТ2023 **75.1%**2024 **78.2%** ▲4%АЖИЛТНЫ
СЭТГЭЛ
ХАНАМЖ2023 **76%**2024 **77.3%** ▲2%ДУНДАЖ АЖИЛЛАСАН ЖИЛ **3.4 ЖИЛ**

АЖИЛЛАХ ОРЧИН, ХАЛАМЖ:

Компани ажилтнуудын ажил амьдралын тэнцвэр, сурч хөгжих боломжийг дэмжих зорилгоор:

- Ердийн цагийн хуваарь,
- Сонголттой цагийн хуваарь,
- Богиносгосон цагийн хуваарь
- Уян хатан гэсэн 4 төрлийн ажлын цагийн хуваарьтай.

Нэмэлт халамж:

Цалинтай 4
өдрийн чөлөө



- Гүйцэтгэл
- Бүтээмж
- Зорилтын
урамшуулал



Бяцхан үрсийг
дэмжих
хөтөлбөр



Ажилтан
бүр хувьцаа
эзэмшигч



Эрүүл
мэндийн
даатгал, үзлэг



Хуримтлалын
багц



Гэнэтийн ослын
даатгал



Хоол, унааны
хөнгөлөлт



Дотоод, гадаадын
сургалт, хөгжлийн
боломж



Утасны
хөнгөлөлт







260 гаруй ажилтны гал тогоо




Фитнесийн өрөө



Дундын оффис



Хурал, уулзалтын танхим



Сургалт, хөгжлийн танхим



Бариа заслын өрөө



Амралтын өрөө



Ганцаарчилсан уулзалтын өрөө

АЖИЛТНУУДАД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨРҮҮД



МОНОС БАХАРХАЛЫН ӨДӨР

Монос Хүнс ХК-ийн “Монос Бахархалын өдөр” нь жил бүрийн 9 сарын 17-нд уламжлан болгон зохион байгуулдаг. Тухай өдөр нь өндөр бүтээмжтэй өдөр байх зорилт тавин өдрийн гүйцэтгэлээ хэмжиж, дотооддоо мэдээлэл хүргэдэг. Энэ нь байгууллагын нэр хүнд, үнэт зүйлсийг ажилтнуудад таниулах, хамт олны бахархлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ юм.



8/18 АРГА ХЭМЖЭЭ

Монос Хүнс ХК нь Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон Монгол цэргийн баярыг тохиолдуулан жил бүр уламжлал болгон “8/18” арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ нь хамт олны эв нэгдэл, ажиллах уур амьсгалыг сайжруулахад эерэг үр нөлөө үзүүлдэг.



СПОРТ ЗААЛ

Урлаг, спортын арга хэмжээг жилд тогтмол зохион байгуулдаг ба ажилтны эрүүл мэнд, хамт олны уур амьсгалыг сайжруулах зорилгоор спорт заалтай гэрээ байгуулан, ажилтнууд 7 хоног бүр тогтмол спорт зааланд чөлөөт цагаа өнгөрөөдөг.



СПОРТ АРГА ХЭМЖЭЭ

Монос Хүнс ХК-ийн спортын наадам Спортын арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг ба энэ жил “Би биш Бид” уриан дор болж өнгөрсөн юм. Энэ удаагийн спортын их наадамд бүх албадуудын 250 гаруй ажилтнуудыг хамруулсан ба нийт зургаан багт хуваагдаж, зургаан төрлөөр 36 багц медалийн төлөө оюун ухаан, хурд хүчээ уралдуулан өрсөлдлөө.



ШИНЭ АЖИЛТНЫГ ЧИГЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монос Хүнс ХК-ийн шинэ ажилтнуудаа компани болон группийн ХОЁР удаагийн чиглүүлэх сургалтанд хамруулдаг бөгөөд энэхүү сургалтаар компанийн хэмжээнд дагаж мөрдөх хэм хэмжээ, компанийн үүсэл түүх, одоо болон ирээдүйн зорилго, зорилт, төслүүд, нэвтрүүлсэн чанарын стандартууд, үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнүүдийн дэлгэрэнгүй танилцуулга болон дотооддоо карьер өсгөх боломж зэрэг мэдээллүүдийг ажилтанд өгдөг.

СОНИРХОЛЫН КЛУБУУД

Бид 2024 оноос хойш ажилтнуудынхаа сонирхол, хоббиг дэмжиж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, хамт олны хоорондын уялдаа холбоог сайжруулах үүднээс “Сонирхолын клуб”-үүдийг байгуулан тогтмол үйл ажиллагааг явуулж байна.



СУРГАЛТ, ХӨГЖИЛ:

Монос Хүнс ХК нь сургалт хөгжлийн журмыг мөрдлөг болгон жил бүр ажилтнуудын хувийн хөгжлийн төлөвлөгөөг гаргуулан авч, ур чадварын матрицаар ажилтанд шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлон, бүтэн жилийн гадаад болон дотоод сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу болон цаг үеийн шаардлагатай сургалтуудыг зохион байгуулан ажилладаг.

Сургалтын төлөвлөгөөг

- Ерөнхий ур чадварын,
- Мэргэжлийн ур чадварын,
- Нарийн мэргэжлийн сургалт гэж ангилан боловсруулдаг.

Ажилтнуудаа Монгол улсын томоохон байгууллагуудын сургалтанд хамруулахаас гадна, гадаад улсад зохион байгуулагдах сургалт, семинар, форум, экспод жил бүр хамруулдаг.

СУРГАЛТЫН ТОО 98

ХАМРАГДАСАН НИЙТ АЖИЛТНЫ ТОО


1503

СУРГАЛТАД ХАМРАГДСАН ЦАГ

480.5

СУРГАЛТЫН НИЙТ ЗАРДАЛ

44.4 САЯ ₮



МФС ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Ослыг тэглэх, эрүүл аюулгүй ажлын байр бий болгох, хүн бүр ХАБЭА манлайлагч байх зорилтыг дэвшүүлж, нийт ажилтны сургалт, ажлын байрны үзлэг шалгалт, галын анхан шатны багаж хэрэгсэл, анхны тусламжийн цэгийг байнга шалган, үйл ажиллагааны онцлогоос хамаарсан онцгой байдлын сургалт, замын цагдаагийн сургалт, улаан загалмайн сургалт дадлагыг төлөвлөгөөний дагуу хийж байна.

Мөн ХАБЭА орон тооны бус байнгын зөвлөлийг ажиллуулж, Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх байнгын комиссыг ажиллуулж осол, осолд дөхсөн тохиолдлыг судлан бүртгэж, осолд дөхсөн тохиолдлуудад дүн шинжилгээ хийж бодит ослоос урьдчилан сэргийлэх ажлуудыг төлөвлөн, хэрэгжүүлж ажиллаж байна.

СУРГАЛТ

32 УДАА

ХАМРАГДАСАН НИЙТ
АЖИЛТНЫ ТОО

480

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ

2024

ХАМРАГДАСАН НИЙТ
АЖИЛТНЫ ТОО

207

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН АЖИЛЧДЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ


жилд 2 УДАА

ДАВХАРДСАН ТООГООР 271

ХАБЭА-н чиглэлээр хэд хэдэн төрлийн хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тухайлбал:



Дархлаажуулалтыг дэмжих
хөтөлбөр



Аюулыг арилгах, осол гэмтээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд аюулыг мэдээлэх хөтөлбөрийг 14 хоногийн хугацаанд зарлаж байна. Та ажлын байран дээр олж харсан аюул эрсдэлийг, аюулыг мэдээлэх хуудас болон Фейсбүүк платформ ашиглан хэдэн ч аюулыг мэдээлэх боломжтой.
Хамгийн эрсдэлтэй, зөв аюулыг илрүүлсэн болон сайжруулах оногчтой арга хэмжээг санаачилсан ажилтнуудад шаталтай.

Ажлын байрны аюулыг
мэдээлэх аян

MFC СОЁЛ

MFC RETREAT

Ирэх оны бизнесийн гол зорилтуудаа тодорхойлдог **Retreat** арга хэмжээг Бизнес хөгжлийн албанаас **8 дах жилдээ** зохион байгуулсан ба 2025 онд хэрэгжүүлэх 38 гол зорилт болон 2026, 2027 онд үргэлжлүүлэх гол зорилтуудаа тодорхойлсон юм. 2025 онд эхлүүлсэн болон хэрэгжсэн төслүүддээ төвлөрөн савласан цэвэр усны зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, хуурай хүнсний үйлдвэрлэл буй бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж борлуулалтын орлогыг солонгоруулах, БОНЗ-ийн бодлогыг нутагшуулан оролцогч талуудаа татан оролцуулах, ажилтнуудын тогтвортой ажил эрхлэлтийг бодлогоор дэмжих, ажилтны бүтээмжийн нэмэгдүүлэх чиглэлээр чадавхжуулах сургалтуудад хамруулах зэрэг гол зорилтууд тодорхойлсон.


MFC FAMILY

“MFC Family” нь Монос Хүнс ХК-ийн соёл, үнэт зүйлсийг ажилтнуудынхаа бодит жишээн дээр тулгуурлан түгээж, байгууллагын дотоод уур амьсгал, ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд бодитой үр нөлөөтэй юм.

MFC ADVICE

MFC Advice нь Монос Хүнс ХК-ийн эмч төлөөлөгчдийн багийн зүгээс сүүлийн гурван жилийн хугацаанд бэлтгэн хүргэж буй эрүүл мэндийн анхан шатны зөвлөмжийг энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргэж, үзэгч, хэрэглэгчдэд хэрэгцээтэй мэдээллийг хүргэдэг.

RETREAT 2023



ТУЛГЫН ГУРВАН ЧУЛУУ



UPDATE AND
RESTART

MFC RETREAT 2025
HIGHWAY



МФС ХАРИЛЦАГЧИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Жил бүр Бэлтгэн нийлүүлэгчид өдөрлөг зохион байгуулдаг ба 14 компанийн 24 ажилтанд олон улсын стандартууд болон Байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээний мэдээлэл өгөн, үйлдвэртэй танилцах үйл ажиллагааг зохион байгуулав.

МФС TOUR: ҮЙЛДВЭРИЙН АЯЛАЛ


“MFC Tour” үйлдвэрийн аяллыг амжилттай зохион байгуулж нээлттэйгээр хүлээн авах үйл ажиллагааны эхлэлийг тавьсан. Үйлдвэрийн аяллын хөтөлбөр нь оюутан, сурагчдад мэдлэг олгохын сацуу байгальд ээлтэй шийдэл, хандлагыг таниулах, хариуцлагатай хэрэглээг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

МФС NEWS ДОТООД ВИДЕО КОНТЕНТ

Монос Хүнс ХК нь ажилтнуудын дотоод мэдээллийн хүртээмж, байгууллагын уур амьсгал, харилцаа холбоог сайжруулах зорилгоор “MFC News” нэртэй видео цуврал контентыг дотоод групптээ тогтмол байршуулж байна.

МФС ОД

Жил бүр Монос Хүнс ХК-ийн хамт олон Баярын хурал зохион байгуулж, өнгөрсөн оны амжилт ололтоо дүгнэж, ирэх оны зорилттой танилцаж, тухайн жилийн шилдэг, өндөр бүтээмж бий болгосон ажилтнуудаа тодруулан МФС Од тэмдгээр шагнаж урамшуулдаг.



5

ИЛ ТОД БАЙДАЛ

ЗАСАГЛАЛ

Монос Хүнс ХК-ийн засаглалын дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд 2024.09.09 өдрийн байдлаар 12880 хувьцаа эзэмшигчтэй болоод байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль, дүрэмд зааснаар жилд нэг удаа зохион байгуулдаг.

Монос Хүнс ХК нь 13 албатайгаар үйл ажиллагаа явуулдаг. Матриц удирдлагын хүрээнд Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн баг, Эрсдэлийн баг, Онцгой байдлын баг, Хүнсний аюулгүй байдлын багууд нь өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилладаг.

ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

2024-01-01 өдрөөс 2024-09-09 өдрийг хүртэл ТУЗ 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, 2024-09-09 өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын өдрөөс хойш ТУЗ 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

2024-09-09-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар нийт 20 нэр дэвшигчээс 6 ердийн, 5 хараат бус нийт 11 гишүүнийг томилов.

2024 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн тоо нэмэгдсэнээр компанийг удирдлагаар хангах сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, үүрэг зөвлөмж, төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлэн, тайлант хугацаанд тогтмол хуралдаж компанийн үйл ажиллагаанд нийт 40 үүрэг зөвлөмж өгснөөс 96%-ийн биелэлттэй байна. Засаглалын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Шүгэл үлээх журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам, Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг хэлэлцэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

2024 оны 4-р сарын 20-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодыг 4 болгон шинэчилжээ.

- Цалин, урамшууллын хороо (1 хурал)
- Нэр дэвшүүлэх хороо (4 хурал)
- Аудит, эрсдэлийн хороо (5 хурал)
- Стратеги, бизнес хөгжлийн хороо (2 хурал)

ТУЗ-ИЙН ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 онд ТУЗ нийт 10 удаа танхим, цахим, эчнээ санал хураалтын хэлбэрээр хуралдсанаас ээлжит хурал 4, ээлжит бус хурал 6 удаа хуралдаж, нийт 17 тогтоол гаргасан.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН:

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээг тогтмол хийдэг бөгөөд уг үнэлгээг ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, аудит, хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал, оролцогч талуудын эрх ашиг, компанийн соёл, хувьцаа эзэмшигчдийн эрх зэрэг зарчмуудын хүрээнд хийж, **98%-ийн үнэлгээ авсан.**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ:

ҮЦБЖ дагуу Монголын Хөрөнгийн Бирж, компанийн вэб хуудаст 2024 онд дараах мэдээллийг байршуулаад байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ВЭБ ХУУДАСТ

- Улирлын болон жилийн эцсийн санхүү тайлан
- Хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан
- БОНЗ-ын үнэлгээний хураангуй тайлан
- КЗК-ын хэрэгжилтийн тайлан
- ХЭЭХ-ын зар, мэдэгдэл
- ХЭЭХ-аас гарсан шийдвэр
- ТУЗХ-ын шийдвэр, тэмдэглэл
- КЭБАТ-ы мэдээлэл



Монголын
Хөрөнгийн Бирж

КОМПАНИЙН ВЭБ ХУУДАСТ

- Хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан
- БОНЗ-ын үнэлгээний тайлан
- КЗК-ын хэрэгжилтийн тайлан
- ХЭЭХ-ын зар, мэдэгдэл
- ХЭЭХ-аас гарсан шийдвэр
- ТУЗХ-ын хурлын товч мэдээлэл
- ТУЗ гишүүд дэлгэрэнгүй мэдээлэл
- ТУЗ-ийн журмууд



Монос Хүнс

ТӨВ ОФФИС:

Сонсголонгийн зам гудамж 32/3 тоот,
Үйлдвэрийн баруун бүс, БГД, 20-р хороо,
Улаанбаатар, 16103, Монгол Улс

МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТЫН АЛБА:

Эко Интернэйшнл тауэр 19 давхар 1908
тоот, СБД, Нэгдүгээр хороо, Улаанбаатар,
Монгол Улс



www.monosfoods.mn



Foods@monos.mn



MonosFoods



976-7777-3525